



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

Ариутгалын ажил зохион байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын хөрсний бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд төвлөрсөн хогийн цэгүүдэд хог тээвэрлэн хүргэсэн хог тээврийн автомашины дугуйгаар тархах нян бактериас үүдэн халдварт өвчин гарах эрсдлийг бууруулах зорилгоор Нарангийн энгэр, Цагаандаваа, Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгээс гарч байгаа автомашины дугуйг ариутгах ажлыг 2019 оны 06 дугаар сарын 05-наас 2019 оны 10 дугаар сарын 05-ны хороонд зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. Төвлөрсөн хогийн цэгт автомашиныг ариутгаж халдваргүйжүүлэх чиглэлээр ажиллах мэргэжлийн байгууллагыг ажиллах нөхцлөөр хангаж, хамтран ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-т үүрэг болгосугай.

3. Төвлөрсөн хогийн цэгт хог тээвэрлэж хүргэсэн автомашинуудад ариутгал хийлгэж хэвшүүлэхэд анхаарч ажиллахыг дүүргүүдийн хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

